



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Сурталчилгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Улаанбаатар хотыг гадаад улсад болон цахим орчинд сурталчлах” зохион байгуулах тухай А/1044 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотыг гадаад улсуудад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын уран бүтээлчдийг урин авчирч, сурталчилгааны нэвтрүүлэг, зураг авалт хийх, түүх, соёлын хөшөө дурсгалыг иргэд, жуулчдад таниулах, алдаршуулах, ажлыг 2023 оны 09, 10 дугаар сард зохион байгуулсугай.

2. Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах 46.315.380 /дөчин зургаан сая гурван зуун арван таван мянга гурван зуун наяд/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


4. Арга хэмжээг зохион байгуулах хөтөлбөрийг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 09 сарын 11 өдрийн
112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ”
АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ахлагч: - Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
- Гишүүд: - Аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
- Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
- Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
- Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга: - Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
 даргын 2023 оны 09 сарын 07-ны өдрийн
 119 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



УЛААНБААТАР ХОТЫГ ГАДААД УЛСАД БОЛОН ЦАХИМ ОРЧИНД СУРТАЛЧЛАХ АРГА
 ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС				
1	Гадаад зочдын онгоцны ирж буцах зардал	3 хүн	2.500.000	5.500.000
2	Зочдын гарын бэлэг /visit Ulaanbaatar brand/	3 ш	200.000	600.000
3	Гадаад зочдын зочид буудлын зардал	3 хүн 7 өдөр	295 000* 3 хүн 7 өдөр	6.195.000
4	Гадаад зочдын тээврийн зардал	7 өдөр багц	4.000.000	4.000.000
5	Гадаад зочдын өдөр, оройн хоол	3 хүн 7 өдөр	360.000	2.520.000
6	Дууны клипний зураг авалт хийгдэх ажлын зардал /Клип, Тик ток, Рийлс/	Багц	13.000.000	13.000.000
7	Улаанбаатар хот болон хот орчмын аялал зохион байгуулах	Багц	1.000.000	1.000.000
8	Гадаад зочдын орчуулагчийн зардал	1 хүн* 7 өдөр	500.000	3.500.000
Хэсгийн дүн				36.315.000
УЛААНБААТАР ХОТЫН ХӨШӨӨ ДҮРСГАЛЫГ ТАЙЛБАРЖУУЛАХ ЦАХИМ ОРЧИНД АШИГЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ				
9	Монгол- Англи хэл орчуулга.	15 нүүр	80.000	1.200.000
10	Монгол- Орос хэл орчуулга.	15 нүүр	80.000	1.200.000
11	Монгол- Хятад хэл орчуулга.	15 нүүр	80.000	1.200.000
12	Монгол- Солонгос хэл орчуулга.	15 нүүр	80.000	1.200.000
13	Кью-Ар код дизайн	27 ширхэг	14.820	400.140
14	Газрын Вэб сайтыг холбох, ажиллуулах.	1 домайн	450.000	450.000
15	Кью-Ар код самбар.	27 ширхэг	161.120	4.350.240
Хэсгийн дүн				10.000.380
Нийт дүн				46.315.380

--- оОо ---